

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН
НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**
№26/01



Огноо: 2026 оны 4 сарын 28

Цаг: 15:00

Байршил: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр, 17 давхар, Криптос ресторан

“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 сарын 28-ны өдрийн 15:00 цагт нээв.

ХУРАЛ НЭЭВ

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Сайн байцгаана уу, юуны түрүүнд Нэгж эрх эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож байгаа нийт нэгж эрх эзэмшигчдэдээ баярлалаа. Өнөөдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлд заасан тооллогын комиссын эрх, үүргийг хэрэгжүүлэхээр Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн хуулийн зөвлөх Ө.Бямбагэрэл миний бие Тооллогын комиссын даргаар, тооллогын комиссын гишүүнээр мөн компанийн дилер Ч.Даваацэрэн мөн компанийн хуулийн зөвлөх Б.Эрдэнэбилэг нар томилогдон ажиллаж байна. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХО нь нийт 50,000,000 ширхэг гаргасан нэгж эрхтэй байна. Үүнээс саналын эрхтэй 50,000,000 нэгж эрх байна. Өнөөдрийн хуралд 25,534,333 ширхэг нэгж эрх эзэмшиж байгаа 51.07 хувийн нэгж эрх эзэмшигч оролцож байна. Иймд, Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг болон Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсгийг тус тус үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болно. Тооллогын комисс.

Ийнхүү Хурлын дэгийн дагуу Ард Менежмент ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Даваасамбууг урьж байна.

Ч.Даваасамбуу: Сайн байцгаана уу, Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэлдээ баярлалаа. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн хурал 15:15 минутаас хугацаандаа болж эхэллээ. Хурлын ирцийн хувьд 51.07 хувийн ирцтэйгээр амжилттайгаар хүчин төгөлдөр болсныг мэдэгдэж байна. Та бүхэнд хурлын дэгийг танилцуулъя. Өнөөдрийн энэхүү хурлаар нийтдээ 11 асуудал хэлэлцэн шийдвэрлэгдэхээр байна. Үүнд:

1. Ард Менежмент ХХК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны тайланг батлах;
2. Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;
3. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг батлах;
4. 2025 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг батлах;

5. Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах;
6. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
7. 2026 оны ТУЗ-ийн зардлын төсөв батлах;
8. Кастодиан банк өөрчлөх тухай шийдвэрийг батлах тухай;
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2026 оноор дуусгавар болж байгаа тул гишүүдийг сонгох;
10. Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах;
11. Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах.

ХЭЛЭЛЦСЭН НЬ №1

“Ард Менежмент” ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан

Ч.Даваасамбуу танилцуулав: Ард Менежмент компанийн тайланг танилцуулъя. Ард Менежмент компани маань 2011 онд үүсгэн байгуулагдсан, 2016 онд санхүүгийн зохицуулах хорооноос үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө авсан. Ард Менежмент компани маань нийт 2 сан удирдаж байна. 2020 онд Монголын анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний хувьчлалын санг үүсгэн байгуулсан. Сангийн хувьд 2020 оны 10 сард үүсгэн байгуулагдаад 2021 оны 2 сар гэхэд нэгж эрхийн зах зээлийн үнэлгээ 750 төгрөг хүртэл өссөн, өндөр өсөлт үзүүлж байсан түүхтэй. Улмаар хөрөнгө оруулалтын санг эрэлт хэрэгцээтэй байна хэмээн үзэж Хөрөнгө оруулагч үндэстэн санг 2022 онд үүсгэн байгуулснаар хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байна. Хөрөнгө Оруулагч Үндэстэн Сангийн онцлогийн хувьд Монголын хөрөнгийн бирж болон бусад хөрөнгийн биржүүдээр арилжаалагддаггүй, зөвхөн Ард аппаар дамжуулан арилжаалагддаг сан байдаг.

Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг манай Сангийн менежер У.Сүхдарь дэлгэрэнгүй танилцуулах болно.

У.Сүхдарь танилцуулав: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг У.Сүхдарь гэдэг. Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн сангийн менежерээр 2024 оны 7 сараас эхлэн томилогдон ажиллаж байна. Та бүхэнд сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулъя. Юуны түрүүнд, хөрөнгө оруулалтын сан бол хөрөнгө оруулалт хийдэг компани тул Сангийн үндсэн үйл ажиллагааг танилцуулахаас өмнө 2025 онд эдийн засаг болон хөрөнгийн зах зээл ямархуу дүр зурагтай байсан бэ талаар товч танилцуулъя.

2025 онд Монгол Улсын эдийн засаг, ер нь ковидоос хойш ДНБ-ийн өсөлт тогтмол өссөн байгаа. Энэ нь голчлон уул уурхайн салбартай холбоотой байдаг. Гэхдээ өнгөрсөн 2023, 2024 оны хувьд уул уурхайн салбарын зэрэгцээ хөдөө аж ахуйн салбар уналттай байсан. 2025 оны хувьд бидний хүлээлт бол уул уурхайн салбар бол унах боломжтой, нүүрсний үнэ буурсан, биет хэмжээ багассан нөгөө талдаа геополитикийн асуудлууд үэрэг хүнд асуудлууд тулгарах боломжтой юм байна гэсэн хүлээлттэй байсан. Ийм хүлээлттэй байсан хэдий ч

2025 оны сүүлийн хагаст нүүрсний биет хэмжээ нэмэгдэж, зэсийн үнэ нэмэгдсэн. Улмаар эдийн засгийн өсөлт хүлээлтээс дээгүүр гарч бодит ДНБ-ийн өсөлт 6.8 хувь гарсан. Үүнийгээ дагаад бидний эспорт сайжирч, нүүрсээ гаргаж чадсан тул нэг талдаа төгрөг чангарч, инфляц харьцангуй тогтворжиж, Монголбанкнаас бодлогын хүүг тогтмол 12 хувьд барьж байв. Тэгэхээр 2025 хувьд макро эдийн засгийн орчин хүлээлтээс дээр болж өнгөрлөө.

Хөрөнгийн зах зээлийн орчны хувьд мөн ялгаагүй Ковидоос хойш тогтмол өсч байна. Арилжааны ТОП-5 банк Ковидоос хойш та бүхний мэдэхээр IPO хийлээ. Хөрөнгийн зах үзэл тэлж, нэг талдаа 2023 онд арилжааны банкууд IPO хийсэн, 2024 оны хувьд компанийн бондууд түлхүү гарсан байдаг. Харин 2025 оны хувьд харьцангуй тайван буюу шинээр бонд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгслүүд харьцангуй бага байлаа.

Ингээд сангийн үндсэн гүйцэтгэл рүү орцгооё. Үндэсний Хувьчлалын Сангийн хувьд хаалттай сан гэж явдаг. Монгол Улсын Хөрөнгийн биржээр арилжаалагддаг. Ингэхдээ бидэнд хоёр тусдаа ханш байдаг. Зах зээлийн ханш буюу эрэлт, нийлүүлэлтээр тогтдог, нөгөө талдаа цэвэр хөрөнгийн үнэлгээ буюу нэг нэгжид ногдох хөрөнгө хэд байгаа юм бэ гэдгийг хардаг цэвэр хөрөнгийн үнэлгээ (Net Asset Value) буюу NAV гэж ханш байдаг.

Эндээс харахад зах зээлийн үнэлгээ 95.92 энэ бол анхны үнээс -2.8 хувь унасан, өмнөх жилтэй харьцуулахад -14.8 хувь унасан. Цэвэр хөрөнгийн үнэлгээний хувьд 151.16 энэ нь анхны үнээс +51.2 хувь өссөн. Өмнөх жилтэй харьцуулахад +12.3 хувь мөн өссөн үзүүлэлт байгаа. Ингээд энэ хоёр үнэлгээг харах юм бол зах зээл дээр 52.4-өөр хямд үнэлгээтэй арилжаалагдаж байдаг гэсэн үг. Үндсэндээ та 95.92 төгрөгөөр 151.16 төгрөгийн үнэ цэн бүхий хөрөнгийг Монголын Хөрөнгийн Биржээс худалдаж авдаг гэсэн үг. Сүүлийн үед бага үнэлгээтэй үед зах зээлээс түүж авах нь илүү зохистой, сангийн үйл ажиллагаа дуусад үед би 80 төгрөгөөр авсан хөрөнгө ирээдүйд илүү өсөх боломжтой гэдэг утгаар хүмүүс илүү түүж авах хандлагатай байгаа. Цэвэр хөрөнгийн үнэлгээний хувьд 2022 оны 4 сараас хойшхи хамгийн дээд цэвэр хөрөнгийн үнэлгээнд хүрсэн байгаа.

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн үнэлгээний хувьд сан нийт 10 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулна. Улмаар 2029 он хүртэлх гүйцэтгэлийн төлөвлөгөөг харуулж байна. Энд сангийн хөрөнгө тогтмол өссөөр явж байгаа гэж харагдаж байна. Мэдээж сангийн үндсэн үйл ажиллагааны хувьд хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэх ёстой. Манай багцад дотоодын 24 хувьцаа, гадаад 6 хувьцаа, 1 үнэт цаас гэсэн бүрэлдэхүүн хэсэг байна. Бид өмнөх нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хөрөнгө оруулалтын бодлогодоо гадаад хувьцааг багцын 20 хувь хүртэлх хэмжээнд өсгөх төлөвлөгөөтэй байгаа гэж танилцуулж байсан. 2025 оны эцсээр 20 хувь хүртэлх өсгөнө гэх төлөвлөгөөний 14 хувьд барьж, нийт багцын 90 хувийг хувьцаа эзэлсэн. Энд харагдаж байгаагчлан багцын 7 хувийг үнэт цаас эзэлж байна.

Хувьцааны багцуудыг салбараар нь дэлгэрэнгүй харвал, технологийн салбар байна. Бидний мэдэх Alphabet, AST, Plug, Google гэх зэрэг гадаад хувьцаа түлхүү технологийн салбарт байна. Уул уурхайн салбарын хувьд Таван толгой, Steppe Gold, Ivanhoe electric, Эрдэнэ

ресурс зэрэг байна. Тогтмол хэрэглээ гэж байгаа энд бидний мэдэх үндэсний томоохон 3 компани байна. Санхүүгийн салбарын хувьд мэдээж ойлгомжтой, Монголын ТОП-20 индексийн 60 орчим хувь нь санхүүгийн компаниуд байдаг. Тэр дундаас бид өөрсдийн үнэлгээгээр хөрөнгө оруулсан компаниуд харагдаж байна. Багцад нэг хувьцаа буюу эрдэнэ ресурсийн хувьцаа дангаараа 12 хувийг эзэлж байгаа. Бусад нь түмэн шувуут 7.7 хувь, Ард Санхүүгийн Нэгдэл 7.6 хувь, Лэнд 6.27 хувь, АрдКредит 6.08 хувь гэсэн манай багцын ТОП-5 хувьцаа харагдаж байна.

Онцлох хөрөнгө оруулалтын хувьд бид өнгөрсөн онд Хөрөнгө оруулалтын бодлогоо шинэчилсэн. Гадаад хувьцааг багцын 20 хувь хүртэл өсгөх бодлоготой байгаа гэж дурдсан. Энэ хүрээнд Applied Materials гээд компани байгаа. Компанийн хувьд АНУ-ын компани, чипний үйлдвэрлэлийн бүх тоног төхөөрөмж, програм хангамжаар хангадаг компани байгаа. Энэ бол үндэсний хэмжээний компани, тус компанийн хувьд багцад 2 дугаар улирлын байдлаар багцын 1,7 хувь хүртэл хөрөнгө оруулалт хийгээд жилийн эцэст нийт 26.9 хувийн өгөөж хүртэж чадсан. Дараа нь Ivanhoe electric гэж байгаа. Энэ компани нь дэвшилтэт технологиор хайж илрүүлэх, энгийнээр бол уул уурхайн компани. Оны эцэс гэхэд 33.9 хувийн өгөөж хүртсэн. Бид салбарыг нийтэд нь багцад эзлэх хувиар нь харах юм бол метал, уул уурхайн салбар байгаа нь 2025 оны эцэст дээгүүр байр эзэлж байгаа. Энэ нь алтны үнэ, геополитикийн нөхцөл байдалтай холбоотой. Ингээд нийт 14 салбарын хувьцааг хөрөнгө оруулалтын багцдаа бүрдүүлж ажиллаж байна.

2025 оны хувьд нийт 7,100 нэгж эрх эзэмшигчидтэй, өмнөх онтой харьцуулахад 3.1 хувь өссөн үзүүлэлт байгаа. Сүүлийн гурван жилд сангийн нэгж эрх эзэмшигчдийн тоо тогтмол нэмэгдэж байгаа. Энд, нэгж эрх эзэмшигчдийн хөдөлгөөнийг харах юм бол Ард Даатгал 11.3 хувиас 10.5 хувь, Ардын Тэтгэврийн Данс 5.7 хувиас 7.3 хувь, Тулга өөрчлөлтгүй, Ард Менежмент 5 хувиас 5.1 хувь,

2025 онд нийт 42 компани 1.1 их наяд төгрөгийн буюу түүхэн хамгийн өндөр ногдол ашиг тараасан жил болсон. 2026 оны хувьд нийт 48 компани 982 орчим тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэр гаргасан. Энэхүү 982 тэрбум төгрөгийн 96 хувь нь буюу дийлэнх хувь нь Монголын хөрөнгийн биржийн нэгдүгээр ангилалд багтдаг 21 компанийн тараах ногдол ашгийн дүн болно. Энэ дотроо нээлттэй 5 банкны тарааж байгаа ногдол ашиг нь нийт тарааж байгаа ногдол ашгийн 60 орчим хувийг эзэлж байгаа.

Санхүүгийн тайлан руу орцгооё. Сангийн хувьд 2025 онд нийт 7,554 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй. Үүнээс бэлэн мөнгө 209, санхүүгийн хөрөнгө (бодит) 7,306 сая төгрөг, авлага 26 сая төгрөг, хойшлогдсон татварын хөрөнгө 12 сая төгрөг. Нийт өр төлбөр 7 сая төгрөг үүнээс дансны өгөөг 1 сая төгрөг, хойшлогдсон татварын өр 6 сая төгрөг. Эздийн өмчийн дүн 7,547 сая төгрөг байна. Хуримтлагдсан ашиг бол 2,547 сая төгрөг байна. Орлогын тайлангийн хувьд 2025 онд бодит үнэ цэнийн өсөлтийн олзоос Сан нь 818 сая төгрөгийн олз олсон байна. Ногдол ашгийн орлого 235 сая, хүүгийн орлого 38 сая төгрөг, ингээд зардлуудын хувьд Сангаас тодорхой гарах ёстой зардлууд байдаг. Хөрөнгө оруулалтын

менежментийн үйлчилгээний зардал 148 сая, Кастодиан үйлчилгээний зардал 19 сая, бусад зардал 120 сая буюу энд Нэгж эрх эзэмшигчдийн хурал зохион байгуулах, бусад аудит, мэргэжлийн үйлчилгээний зардлууд орж байгаа. Нийт үйл ажиллагааны зардал улмаар 296 сая төгрөг гараад татварын үеийн өмнөх ашиг 798 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Зардлыг дэлгэрэнгүй харуулбал, сан үүсгэн байгуулагдсан цагаас Хөрөнгө оруулалтын менежментийн зардал гарна. Энэ нь 148 сая, ингээд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр нийт хөрөнгийн 3 хувиас хэтрэхгүй байх ёстой бол эдгээр нийт зардал 2.2 хувийг бүрдүүлснээр сангийн нийт зардал зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Ингээд дараагийн асуудлыг танилцуулна уу хэмээн хурлын дарга Ч.Даваасамбууг урьж байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2

2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах

Ч.Даваасамбуу танилцуулав: Юуны түрүүнд төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Золбоо, ердийн гишүүдээр Г.Цогбадрах, Ч.Хандаа, хараат бус гишүүдээр Б.Ариунболд, П.Баянсан нар ажиллаж байна. 2025 онд Төлөөлөн удирдах зөвлөл 3 удаагийн биет хурал хийсэн. 3 удаагийн эцнээ санал хураалт явагдсан байна. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг цаг тухай бүрд бэлтгэн хүргүүлсэн. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль болон хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журмын хүрээнд ажилласан. Улирал бүр Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийг хуралдуулж, шаардлагатай шийдвэрүүдийг танилцуулсан. Сангийн хагас болон бүтэн жилийн тайланг бэлтгэн олон нийтэд болон зохицуулагч байгууллагуудад тухай бүрд хүргүүлсэн. Зохицуулагч байгууллагуудын хяналт, шалгалт, хөндлөнгийн аудитыг хийлгэсэн. Кастодиан банканд сангийн хөрөнгийг хадгалуулах тайлан, мэдээний үнэн, зөв байдалд хяналт тавин ажилласан гэж дүгнэсэн. Иймд, гүйцэтгэх удирдлагын багийг Монгол Улсын хамгийн анхны хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу удирдаж ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна. Мөн цаашид хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан төлөвлөсөн өгөөждөө хүрч ажиллахыг сангийн менежер болон гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож байна гэж дүгнэлт гаргасан байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №3

Кастодиан банкны Хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан

Голомт банкны Кастодиан банкны хэлтсийн Бизнес хөгжлийн менежер Очир танилцуулав: Сайн байцгаана уу. Голомт банкны Кастодиан банкны Бизнес хөгжлийн менежер Очир миний бие санд үзүүлсэн Кастодиан үйлчилгээний тайланг танилцуулъя.

Энэ хэсэгт хөрөнгийн зах зээлийн бүдүүвч зургийг ерөнхий байдлаар харуулсан. Кастодиан банк нь хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хараат бусаар хадгалж, төлбөр тооцоог нь гүйцэтгэж, тухайлсан нэгж эрхийн бүртгэлийг хийдэг. Мөн ногдол ашиг, орлогын мэдээллийг хүргэж явдаг. Голомт Кастодианы хувьд 2014 онд тусгай зөвшөөрлөө авч байсан, 2017 онд JPMorgan саб-кастодианаар ажилласан. 2018 онд олон улсын кастодианы стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажилласан. 2020 онд зах зээл дэх хамгийн анхны хөрөнгө оруулалтын сан болон Үндэсний хувьчлалын сантай хамтран ажиллаж эхэлсэн. Одоо нийт хамтын 7 сан байдгаас 6 санд нь Голомт банк үйлчилгээ үзүүлж ажиллаж байна.

Үндэсний Хувьчлалын Сангийн хувьд 2025 оны байдлаар удирдаж буй хөрөнгийн хэмжээ 7,6 тэрбум төгрөгт хүрсэн. Үүний 90 хувь нь хувьцаанд, 2.6 хувь нь мөнгөний зах зээлийн хэрэгсэлд, 7 хувь нь бондод хөрөнгө оруулсан байна. Харилцагчдын тооны хувьд 2025 оны эцсийн байдлаар нийт 10,000 гаруй харилцагч байсан бөгөөд нэгж эрхийн цэвэр үнэлгээ 151.16 төгрөгт хүрч, 2024 оноос 12.3 хувийн өсөлттэйгөөр ажилласан байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №4

2025 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын тайланг батлах тухай

Нексия Глобал Монголиа Аудит ХХК, Баярсайхан танилцуулав: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нексия Глобал Монголиа Аудит компанийн аудит менежер Баярсайхан байна. Бид 3 дахь жилдээ ХОС-ийн хөндлөнгийн ажидтын ажлыг хийж гүйцэтгэж байгаа. Манай компани 2021 оноос аудит, санхүүгийн зөвлөх үйлчилгээ, татварын зөвлөх үйлчилгээ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж явж байгаа. 2022 оноос монгол улс дахь хараат бус гишүүн байгууллагаар ажиллаж байгаа. Нексия Интернэйшнл гэдэг нь нийтдээ дэлхийн 125 улсад 270 гаруй гишүүн компаниудын 790 гаруй оффисоос бүрдсэн олон улсын аудитын фирм байгаа. За дэлхийд ТОП-8-д ордог аудитын сүлжээ байгаа. 2022 оноос эхлэн бид гишүүн байгууллагаар ажиллаж байна. Гэрээт ажлын зорилго маань ерөнхийдөө Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангууд нь материаллаг зүйлсийнхээ хувьд Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, холбогдох бусад журам, заавар, аргачлал болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу илэрхийлэгдсэн гэдэгт аудиторын дүгнэлт гаргаж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөхөд оршиж байгаа. Аудитын үйл явц нь 2025 оны 12 сараас эхлээд 2026 оны 3 сарын 27-нд аудитын дүгнэлтийг танилцуулснаар гэрээт ажил дуусгавар болсон. 2026 оны 2 сарыг хүртэл талбарын ажлуудыг гүйцэтгэж, горимуудаа хэрэгжүүлж ажилласан байгаа. Аудитын багийн хувьд Гүйцэтгэх захирал Э.Булган, аудитын татварын партнер Энхмэнд, аудит менежер Баярсайхан миний бие, аудитын туслах Ундармаа гэсэн баг бүрэлдэхүүнтэйгээр Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн дүгнэлтийг гаргасан.

Аудитын дүгнэлтийн хувьд доорх гол үзүүлэлтүүд болох нийт хөрөнгө 7,554 сая төгрөг, үүнээс нийт өр төлбөр нь 7,3 сая төгрөг, нийт өөрийн хөрөнгө 7,547 сая төгрөг байсан. Нийт орлогын хэмжээ 1,092 сая төгрөг, нийт зарлагын хэмжээ 296 сая төгрөг, ингээд татварын өмнөх ашиг 795 сая төгрөг буюу нэгж хувьцаанд ногдох суурь ашиг нь 15,84 төгрөг гэж гарсан байгаа. Бидний дүгнэлтээр дээр нэрлэгдсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал хийгээд тус үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, санхүүгийн байгууллагын тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тольлуулсан гэдэг стандарт дүгнэлтийг өгсөн. Анхаарал хандуулсанд баярлалаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №5

“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай

Ч.Даваасамбуу танилцуулав: Бидний дүрэмд оруулж байгаа гол өөрчлөлт бол сан нэгж эрхээ буцаан худалдан авахтай холбоотой гол өөрчлөлт байгаа. Энэ үндсэндээ ямар давуу тал үүсгэж байгаа вэ гэхээр та бүхний мэдэж байгаачлан нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ 151 орчим төгрөг байгаа гэвч зах зээл дэх арилжаалагдаж буй үнэ 100 орчим төгрөг байна. Энэ нь нэгж эрх маань маш хямдралтайгаар арилжаалагдаж, нөгөө талдаа хөрөнгө оруулагч нар өгөөжөө хүртэх боломжийг хязгаарлаж байгаа. Бид өөрсдийн сангийн хөрөнгөөр нэгж эрхээ буцаан зах зээлээс худалдан авах байдлаар зах зээлийн ханшийг цэвэр хөрөнгийн үнэлгээтэй ойртуулахаар дүрэм болон бусад баримт бичигт холбогдох өөрчлөлтүүдийг тусгаж байгаа. Үндсэндээ одоо байгаа нэгж эрх эзэмшигчдийн нэгж эрхийн үнэ цэнийг өсгөх зорилготой байна.

Гол үндсэн заалтуудыг Ард Менежмент ХХК-ийн хуульч О.Нандинцэцэг танилцуулна.

О.Нандинцэцэг танилцуулав: Сайн байцгаана уу. Ард менежмент ХХК-ийн хуульч Нандинцэцэг байна. Хэлэлцэх асуудлуудын хүрээнд Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн дүрэмд ямар нэмэлт заалтууд орж байгаа вэ гэдгийг хүснэгтэд харуулсан байгаа. Сүүлд Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос 2025 оны 64 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан. Энэхүү журмын 10.3 дахь хэсэгт Сангийн Төлөөлөн удирдах зөвлөл нэгж эрх эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаалж ажиллах үүрэгтэй байхаар заасан. Улмаар Үндэсний Хувьчлалын Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, нэгж эрхийн үнэлгээг цэвэр хөрөнгийн үнэлгээтэй ойртуулах зорилгоор Нэгж эрхийг зах зээлээс эргүүлэн худалдан авах болон буцаан зах зээлд арилжих журмыг сүүлд 2026 оны 4 сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрээр баталсан. Энэ журамтай холбоотой эхний хүснэгтэд байгаа 4.8, 4.9, 4.10 дахь заалтууд нэмэлтээр орж ирж байгаа. Тухайлбал:

4.8. Сан нь энэхүү Дүрмийн 4.1-д заасан зарласан нэгж эрхийн 5 хүртэлх хувь буюу 2,500,000 ширхэг хүртэлх нэгж эрхийг нэгж эрхийн зах зээлийн ханш тухайн үеийн цэвэр хөрөнгийн

үнэлгээ (NAV)-ээс 15 ба түүнээс дээш хувиар бага үнэлэгдэж байгаа тохиолдолд зах зээлээс эргүүлэн авах ажиллагааг хэрэгжүүлж болно.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС нь гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй хаалттай төрлийн сан байгаа. Гэхдээ олон улсад АНУ (BlackRock Closed-End Funds), Их Британи (Scottish Mortgage Investment Trust, Third Point Offshore Investors), Хятад (Templeton Dragon Fund (TDF)) зэрэг улсуудад яг ижил төрлийн хаалттай сангууд нэгж эрхийн үнэлгээ цэвэр хөрөнгийн үнэлгээнээс буурах үед тодорхой хувь хэмжээ дотор эргүүлэн худалдан авдаг жишиг байгаа.

4.9. Энэхүү Дүрмийн 4.8 дахь хэсэгт заасан Сангийн нэгж эрхийг буцаан худалдан авах ажиллагаа нь Сангийн нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, нэгж эрх эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаалах зорилготой байх бөгөөд Сангийн ТУЗ-өөс баталсан журам болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжинэ.

Энэ ажиллагааг ТУЗ-ийн шийдвэр болон Монголын хөрөнгийн биржийн арилжааны журамд нийцүүлэн, нэгж эрх эзэмшигч болон бусад харилцагч талуудад мэдээлэл хүргэснээр хэрэгжүүлэхээр холбогдох заалтыг тусгасан.

4.10. Сан нь буцаан худалдан авсан нэгж эрхээ Сангийн үйл ажиллагааны хугацаа дуусахаас өмнө нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV), Сангийн ТУЗ-өөс баталсан журам, холбогдох шийдвэрийн дагуу зах зээлд буцаан арилжиж болно.

Эдгээр суурь зохицуулалтыг дүрэмдээ тусгаснаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан журмын хэрэгжих эрх зүйн боломжийг бүрдүүлж байна гэж харж байна.

Үргэлжлэх заалтуудын хувьд сүүд батлагдсан Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам болон Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийцүүлэхээр оруулж ирж байгаа заалтууд байгаа. Үүнд:

5.6. Сангийн гишүүний бүртгэлийг Санд үйлчилгээ үзүүлж байгаа менежментийн компани 5.5-д заасан нэгж эрхийн тухайлсан бүртгэлд үндэслэн, сангийн холбогдох дотоод журамд заасны дагуу хөтөлнө.

11.1. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг Компанийн тухай тухай хууль, эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох дүрэм, журамд заасны дагуу зохион байгуулна.

11.2. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд хурлыг хуралдуулбал зохих хугацаа өнгөрсөн өдрөөс эхлэн сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болсонд тооцох ба мөн хугацаанаас хойш байгуулсан аливаа гэрээ хэлцэл, гаргасан шийдвэр хүчин төгөлдөр бус байна.

11.3. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар Сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ болон Менежментийн компанийн дүгнэлтийг заавал хэлэлцэнэ.

11.5.1. Менежментийн компанийг сонгох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах шийдвэр гаргах;

- 11.5.2. Кастодианыг сонгох, хөрөнгө хадгалах гэрээ байгуулах шийдвэр гаргах;
- 11.5.3. Менежментийн компани болон кастодианы төлбөр, урамшууллын дээд хязгаарыг тогтоох;
- 11.6. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдон гарах зардлыг Сан хариуцна.
- 13.7.8. Холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасны дагуу эрх бүхий байгууллага, нэгж эрх эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийг мэдээллээр хангах,
- 18.3. Сангийн нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа этгээд нь эрх бүхий мэргэшсэн нягтлан бодогч байна.
- 22.4. Энэхүү Дүрэмд Нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулна.

Энэ хэсэгт дүрэмд өөрчлөгдөх заалтуудыг харуулж байна. Хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компани болон Кастодиан банкны мэдээллийг дүрэмд заавал тусгасан байх ёстой байдаг. Ард Менежмент компанийн хуулийн этгээдийн нэр Ард Менежмент ҮЦК ХХК байснаас Ард Менежмент ХХК болон өөрчлөгдсөн тул энэхүү өөрчлөлтийг тусгасан. Кастодиан банк өөрчлөх тухай шийдвэрийг хэлэлцэх асуудалд тусгасан тул өөрчлөхөөр төсөл хэлбэрээр оруулсан. Нэгж эрх эзэмшигчдийн хурлаас шийдвэр албажаагүй тохиолдолд энэ заалт өөрчлөгдөхөөргүй байна.

Хасах заалтаар Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл нэгэн адил хамаарна гэсэн заалт орж ирсэн. Хөрөнгө оруулалтын сан нь тусгай зориулалтын компани болохын хувьд тусгай хуульд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуулийн зүйл, заалт шууд хэрэглэгдэхгүй тул Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд энэхүү заалтыг хасах заалтаар оруулсан байна. Баярлалаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №6

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах

Ч.Даваасамбуу танилцуулав: 2025 оны санхүүгийн жилийн гүйцэтгэлийн дүнгээс үзэхэд сан нь эерэг цэвэр ашигтай ажилласан хэдий ч Нэгж эрхийн танилцуулгад тусгасан зорилтот өгөөжийн хувь хэмжээний шаардлагыг бүрэн хангаж чадаагүй үзүүлэлттэй байна.

Иймд сангийн хөрөнгийн өсөлтийг дэмжих, багцын өгөөжийг нэмэгдүүлэх, цаашдын хөрөнгө оруулалтын боломжийг алдагдуулахгүй байх бодлогын үүднээс тухайн тайлант жилийн цэвэр ашгийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилах нь оновчгүй гэж төлөөлөн удирдах зөвлөлөөс үзсэн байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №7

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах

Ч.Даваасамбуу танилцуулав: Зардлын төсвийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын цалин, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын зардал гээд үндсэндээ гурван зардлаас бүрдэж байгаа. Төлөөлөн

удирдах зөвлөлийн дарга бол нэг хурал дээр 2 сая төгрөг, ердийн гишүүд нэг хурал дээр 1 сая төгрөг, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 400 мянган төгрөг гэж оруулсан байна. Улмаар хурал зохион байгуулах зардал 250 мянган төгрөг гээд гурван төрлийн зардал оруулсан байгаа.

Энэ төсөв 2020 оноос хойш явж байгаа нэг ч өөрчлөгдөөгүй асуудал гэж ойлгож болно.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №8

Кастодиан банк өөрчлөх шийдвэрийг батлах

Ч.Даваасамбуу танилцуулав: Бид Голомт Кастодиан банктай хамтран ажиллаж байсан. Өөрчлөн оруулах дээр Хаан Кастодиан банкыг оруулж ирсэн. Та бүхэн танилцаад саналаа өгөөрэй.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №9

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Ч.Даваасамбуу танилцуулав: Өмнө хэлсэнчлэн манай 5 гишүүдийн бүрэн эрхийг хугацаа дуусгавар болсон тул энэ жил сонгуультай жил байна. Та бүхэнд нэр дэвшигчдийг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд Х.Билгүүн, мэргэжил олон улсын эдийн засаг, албан тушаалын хувьд Ард Секюритиз УЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал. Ажилласан жилийн туршлагын хувьд 34 жил байна.

Дараагийн гишүүн Г.Цогбадрах, мэргэжил эдийн засагч, санхүүч, Ард даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг, 31 жилийн туршлагатай хүн байна.

Дараагийн гишүүнээр Ч.Даваасамбуу миний бие нэр дэвшиж байна. Санхүү менежментийн мэргэжилтэй, 8 жилийн ажилласан туршлагатай хүн байна.

Манай хараат бус гишүүнд нэр дэвшигч П.Баянсан. МУИС-ийн Санхүүгийн тэнхиймийн ахлах багш, Докторант, нийт 30 жилийн ажлын туршлагатай, бизнесийн удирдлага мэргэжилтэй нэр дэвшигч байгаа.

Дараагийн нэр дэвшигч маань өөрийн биеэр ирсэн тул танилцуулгаа хийх байх аа.

Б.Ариунболд танилцуулав: Сайн байцгаана уу, Намайг Б.Ариунболд гэдэг. Тус сан дээр 2024 оноос буюу сүүлийн хоёр жил хараат бус гишүүнээр ажиллаж байгаа. Интергрупп Интернэйшнл ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирлаар ажилладаг. Нийт 20 жилийн ажлын туршлагатай, санхүү эдийн засгийн мэргэжилтэй. Хараат бус гишүүнээр ажилладаг болохын хувьд шийдвэр гаргалтдаа хараат бус байдлаар оролцож, нийт нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг төлөөлж ажилладаг гэж үздэг учраас аливаа нэг зүйлд хамааралгүй, бие даасан байдлаар ажилладаг.

Эдгээр гишүүд нэр дэвшсэн та бүхэн саналаа Ард Апп болон цаасан байдлаар өгөөрэй.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №10

Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн Хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах

Ч.Даваасамбуу танилцуулав: Энэ өөрчлөлтүүдийг бид өөрсдөө сангийн нэгж эрхээ эргүүлэн худалдан авах зорилгоор хийж байгаа. Үүнийг нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хийж байна гэж харж байна. Та бүхэн харсанчлан нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ болон зах зээлийн үнэлгээ тогтмол зөрүүтэй байгаа.

- Сан нь нийт зарласан нэгж эрхийн 5 хүртэлх хувь буюу 2,500,000 ширхэг хүртэлх нэгж эрхийг нэгж эрхийн зах зээлийн ханш тухайн үеийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV)-ээс 15 ба түүнээс дээш хувиар бага үнэлэгдэж байгаа тохиолдолд зах зээлээс эргүүлэн авах ажиллагааг хэрэгжүүлж болно.
- Сангийн нэгж эрхийг буцаан худалдан авах ажиллагаа нь нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, нэгж эрх эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаалах зорилготой байх бөгөөд Сангийн ТУЗ-өөс баталсан журам болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжинэ.
- Сан нь буцаан худалдан авсан нэгж эрхээ Сангийн үйл ажиллагааны хугацаа дуусахаас өмнө нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV), Сангийн ТУЗ-өөс баталсан журам, холбогдох шийдвэрийн дагуу зах зээлд буцаан арилжиж болно.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №11

Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн Нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах

Ч.Даваасамбуу танилцуулав: Мөн ижил өөрчлөлт орохоор байна.

- Сан нь нийт зарласан нэгж эрхийн 5 хүртэлх хувь буюу 2,500,000 ширхэг хүртэлх нэгж эрхийг нэгж эрхийн зах зээлийн ханш тухайн үеийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV)-ээс 15 ба түүнээс дээш хувиар бага үнэлэгдэж байгаа тохиолдолд зах зээлээс эргүүлэн авах ажиллагааг хэрэгжүүлж болно.
- Сангийн нэгж эрхийг буцаан худалдан авах ажиллагаа нь нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, нэгж эрх эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаалах зорилготой байх бөгөөд Сангийн ТУЗ-өөс баталсан журам болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжинэ.
- Сан нь буцаан худалдан авсан нэгж эрхээ Сангийн үйл ажиллагааны хугацаа дуусахаас өмнө нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV), Сангийн ТУЗ-өөс баталсан журам, холбогдох шийдвэрийн дагуу зах зээлд буцаан арилжиж болно.

Үүгээр Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал дууссан байна. Одоо дэгийн дагуу санал хураалт явагдана. Энэ хугацаанд нэгж эрх эзэмшигч гишүүдээс асуулт байвал асууя.

САНАЛ ХУРААЛТ

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл

Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. **“Ард Менежмент” ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан батлах тухай** асуудалд саналын эрхтэй 25,534,333 ширхэг нэгж эрх буюу 51.07 хувийн нэгж эрх эзэмшигчид хуралд оролцсоноос 23,026,888 ширхэгийн нэгж эрх эзэмшигчид саналын эрхтэй байх ба үүнээс
Зөвшөөрсөн: 23,025,965 ширхэг буюу 97.6%
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. **2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай тухай** асуудалд саналын эрхтэй 25,534,333 ширхэг нэгж эрх буюу 51.07 хувийн нэгж эрх эзэмшигчид хуралд оролцсоноос
Зөвшөөрсөн: 25,533,410 ширхэг буюу 99.996%
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
3. **Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг батлах тухай** асуудалд саналын эрхтэй 25,534,333 ширхэг нэгж эрх буюу 51.07 хувийн нэгж эрх эзэмшигчид хуралд оролцсоноос
Зөвшөөрсөн: 25,533,410 ширхэг буюу 99.996%
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
4. **2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай** асуудалд саналын эрхтэй 25,534,333 ширхэг нэгж эрх буюу 51.07 хувийн нэгж эрх эзэмшигчид хуралд оролцсоноос
Зөвшөөрсөн: 25,521,410 ширхэг буюу 99.95%
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
5. **Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** асуудалд саналын эрхтэй 25,534,333 ширхэг нэгж эрх буюу 51.07 хувийн нэгж эрх эзэмшигчид хуралд оролцсоноос

Зөвшөөрсөн: 25,533,410 ширхэг буюу 99.996%

Татгалзсан: байхгүй

Түдгэлзсэн: байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

6. **ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай** асуудалд саналын эрхтэй 25,534,333 ширхэг нэгж эрх буюу 51.07 хувийн нэгж эрх эзэмшигчид хуралд оролцсоноос

Зөвшөөрсөн: 25,533,410 ширхэг буюу 99.996%

Татгалзсан: байхгүй

Түдгэлзсэн: байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

7. **Кастодиан банк оорчлох тухай** асуудалд саналын эрхтэй 25,534,333 ширхэг нэгж эрх буюу 51.07 хувийн нэгж эрх эзэмшигчид хуралд оролцсоноос

Зөвшөөрсөн: 4,984,510 ширхэг буюу 19.52%

Татгалзсан: 18,048,900 ширхэг буюу 70.68%

Түдгэлзсэн: 2,500,000 ширхэг буюу 9.7909% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчингүй.

8. **ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай** асуудалд саналын эрхтэй 25,534,333 ширхэг нэгж эрх буюу 51.07 хувийн нэгж эрх эзэмшигчид хуралд оролцсоноос

8.1.Нэр дэвшигч: Х.Билгүүн

8.1.1. Зөвшөөрсөн: 25,487,879 ширхэг буюу 99.82%

8.1.2. Татгалзсан: байхгүй

8.1.3. Түдгэлзсэн: байхгүй

8.2.Нэр дэвшигч: Г.Цогбадрах

8.2.1. Зөвшөөрсөн: 25,458,928 ширхэг буюу 99.7%

8.2.2. Татгалзсан: байхгүй

8.2.3. Түдгэлзсэн: байхгүй

8.3.Нэр дэвшигч: Ч.Даваасамбуу

8.3.1. Зөвшөөрсөн: 25,448,478 ширхэг буюу 99.66%

8.3.2. Татгалзсан: байхгүй

8.3.3. Түдгэлзсэн: байхгүй

8.4.Нэр дэвшигч: П.Баянсан

8.4.1. Зөвшөөрсөн: 25,388,893 ширхэг буюу 99.43%

8.4.2. Татгалзсан: байхгүй

8.4.3. Түдгэлзсэн: байхгүй

8.5.Нэр дэвшигч: Б.Ариунболд

8.5.1. Зөвшөөрсөн: 25,397,397 ширхэг буюу 99.46%

8.5.2. Татгалзсан: байхгүй

8.5.3. Түдгэлзсэн: байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

9. **Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн Хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах тухай** асуудалд саналын эрхтэй 25,534,333 ширхэг нэгж эрх буюу 51.07 хувийн нэгж эрх эзэмшигчид хуралд оролцсоноос
Зөвшөөрсөн: 25,533,410 ширхэг буюу 99.996%
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
10. **Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн Нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах тухай** асуудалд саналын эрхтэй 25,534,333 ширхэг нэгж эрх буюу 51.07 хувийн нэгж эрх эзэмшигчид хуралд оролцсоноос
Зөвшөөрсөн: 25,534,333 ширхэг буюу 100%
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Ч.Даваасамбуу Нэгж эрх эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийг танилцуулав.


ХУРЛЫН ХААЛТ

Ч.Даваасамбуу: Нийт нэгж эрх эзэмшигчдэд хандан хуралд идэвхтэй оролцсонд талархал илэрхийлэн өнөөдрийн хурал амжилттай өндөрлөж буй зарлан хурлыг хаав.

Хурал 17:00 цагт дуусав.

Хянасан:

Хурлын дарга Ч.Даваасамбуу



Тэмдэглэл хөтөлсөн:

О.Надинцэцэг

